

**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ
ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 05 дугаар
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх, Монгол Улс “Санхүүгийн дансны мэдээллийг автоматаар солилцох тухай эрх бүхий этгээд хоорондын олон талт хэлэлцээр”-т нэгдэж, 2027 оноос автоматаар харилцан мэдээлэл солилцох стандартыг хэрэгжүүлж эхлэхээр болсонтой холбогдуулан уг стандартыг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгах, татварын таатай орчныг бүрдүүлж иргэд, аж ахуйн нэгжүүдийг дэмжих, татвар төлөгчдийг татварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мөн татварын бааз суурийг нэмэгдүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар татвар төлөгчийг татварын эрсдэлд орохоос урьдчилан сэргийлж, татварын өр барагдуулах үйл ажиллагаа уян хатан болохын зэрэгцээ татварын таатай орчин бүрдэнэ гэж үзсэн байна.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин хуулийн төсөлд татварын өрийг гаргуулсны дараа татвар төлөгчийн банкин дахь дансанд ирээдүйд орж ирэх мөнгөн хөрөнгөөс үл мөргөх журмаар гаргуулах татварын өрийн хэмжээ нь тухайн орлогын 80 хувиас хэтрэхгүй байх гэсэн заалтын талаар холбогдох тооцоо, судалгаа хийгдсэн эсэх, энэ хувийг 50 хувь болгосон тохиолдолд үүсэх эрсдэлийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд санал хэлээгүй болно.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 62.5 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Н.НАРАНБААТАР